

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2016 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2016.11.16

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" хөтөлбөрт бизнес эрхлэлтийг дэмжих, санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлэх, тэр дундаа санхүүгийн зах зээлд банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэх, цаашлаад тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулж, улсын бүртгэл болон татварын тогтолцоог цахимжуулах, бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөржүүлэх арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Мөн УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлж, хугацааг уртасгах, давхардсан хяналт, шалгалт, хүнд суртлыг арилгах, зах зээл дэх шудрага өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсон байна.


Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 2016 онд дараах журам, заавар, аргачлалыг шинэчлэн баталсан. Үүнд:

№	Журам, заавар, аргачлал	Шийдвэрийн огноо, дугаар	Тайлбар
1.	"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар"	2016.03.11 №71	ББСБ-ыг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан 3 ангилж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл шаардлагуудыг нарийвчлан тодорхойлж, зохицуулалтын хэм хэмжээг тогтоосон.
2.	"Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"	2016.03.11 №72	"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам" шинэчлэн батлагдсантай холбогдуулан ББСБ-ыг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон бөгөөд алслагдсан дүүрэг, хөдөө орон нутагт хямд өртөг бүхий санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэх, ББСБ-уудыг дэмжих бодлогыг хэвээр хадгалсан. ББСБ-ууд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллах үүрэг хүлээсэн байна.
3.	"Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"	2016.10.18 №271	Шинээр тусгай зөвшөөрөл хүссэн ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
4.	"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"	2016.05.17 №147  2016.09.21 №269 <i>/өөрчлөлт оруулсан/</i>	ББСБ-ын өөрийн хөрөнгө, эх үүсвэрийн зөв оновчтой бүтцийг бий болгох, эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор ББСБ-д мөрдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан ялгавартай тогтоосон. Учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс зохицуулалтын байгууллагууд зохистой харьцааны

	шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг улирал бүр ирүүлэхээс гадна цаашид итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн тайлан, зээл олголт, эргэн төлөлт, хүүгийн судалгааны тайлан, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан, гадаад валют арилжааны мэдээг сар бүр тогтоосон хугацаанд ирүүлж байхаар болсон байна.
--	--

(Дүрслэл)

1)



Тайлант оны гуравдугаар улирлын байдлаар 509 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2006 оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин, оны эхнээс 13 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 63 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 4 банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 1 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна. Үүнд:

(Хүснэгт 1)

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл				Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
		шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	сэргээсэн	
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 он	120	5	5	1	378
10	2015 он	80	8	6	5	450
11	2016-III улирал	63	4	-	1	509

Түүнчлэн тайлант улиралд Хороо зээлийн үйл ажиллагаа, гадаад валютын арилжаа, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр хоёр ББСБ-д, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр нэг ББСБ-д, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр дөрвөн ББСБ-д нэмж олгох, нэг компанийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэнээр ББСБ-уудын эрхлэх үйл ажиллагааны төрөлд дараах өөрчлөлт орсон байна.

Харин нэр бүхий 3 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны санаачлагаар, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг өөрийн хүсэлтээр хүчингүй болгох, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээх арга хэмжээ авсан байна.

2016 оны гуравдугаар улирлын байдлаар нийт ББСБ-ын 89.2 хувь буюу 454 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 28.1 хувь буюу 143 ББСБ гадаад валютын арилжаа, 6.5 хувь буюу 33 ББСБ хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.5 хувь буюу 28 ББСБ итгэлцлийн үйлчилгээ, 4.3 хувь буюу 22 ББСБ факторингийн үйлчилгээ, 3.1 хувь буюу 16 ББСБ төлбөрийн баталгаа гаргах, 2.3 хувь буюу 12 ББСБ цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь буюу 2 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан эрхлэх үйл ажиллагааны төрлөөр ББСБ-уудыг ангилвал:

(Хүснэгт 4)

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2015-III	2016-III	тоо	хувь
	Нийт ББСБ	442	509	67	15.2
1	Зээлийн үйл ажиллагаа	380	454	74	19.5
	<i>Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	<i>277</i>	<i>337</i>	<i>60</i>	<i>22.0</i>
2	Факторингийн үйлчилгээ	17	22	5	29.4
3	Төлбөрийн баталгаа гаргах	13	16	3	23.1
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	2	2	100
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	12	6	100
6	Гадаад валютын арилжаа	132	143	11	8.3
	<i>Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	<i>51</i>	<i>51</i>	<i>-</i>	<i>-</i>
7	Итгэлцлийн үйлчилгээ	26	28	2	7.7
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	-	-
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	26	33	7	26.9

2016 оны гуравдугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 509 ББСБ-ын 66.2 хувь буюу 337 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 10 хувь буюу 51 ББСБ гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байгаа нь хамгийн их эрэлттэй үйлчилгээ болох нь харагдаж байна.

Он дамжин үргэлжилсэн эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэргүй байдлаас шалтгаалан Монгол улсын эдийн засагт хүндрэл тулгарч байгаа хэдий ч салбарт оролцогчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 67 компани буюу 15.2 хувиар, тэр дундаа зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 74 компаниар буюу 19.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарч байна.

Тусгай зөвшөөрөлтэй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчдийн тоо 1 дахин, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ эрхлэгчдийн тоо 26.9 хувиар, факторингийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 29.4 хувиар тус тус нэмэгдсэн хэдий ч дээрх үйлчилгээг эрхлээгүй байна.

2016 оны гуравдугаар улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 509 ББСБ-аас 487 ББСБ /95.7%/ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд харин нэр бүхий 12 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр, 10 ББСБ өмнөх үеийн санхүүгийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан болно. Эдгээр ББСБ-уудын хувьд Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 7.1.1, 7.1.3, 7.7.7 дахь заалтын түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл бүрдсэн байх тул цаашид үйл ажиллагаагаа зөв оновчтой зохион байгуулж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 724.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар, оны эхнээс 16.2 хувиар тус тус өслөө. Энэхүү өсөлтөд ББСБ-уудын өөрийн хөрөнгө 138.0 тэрбум төгрөгөөр буюу 35.1 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 103.3 тэрбум

төгрөгөөр буюу 34.6 хувиар өссөн нь голчлон нөлөөлж байна. Активын өсөлтийг 2013, 2014 оны мөн үетэй харьцуулахад харгалзан 12.0, 17.9 нэгж хувиар буурсан байна.

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө нь санхүүгийн зах зээлийн 95 орчим хувийг дангаар бүрдүүлдэг банкны салбарын 68.1 хувьтай тэнцэж байгаагаас үзэхэд ББСБ-ууд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр бус хувьцаа эзэмшигчдийн дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах замаар үйл ажиллагаа эрхэлж байгааг харуулах чухал үзүүлэлт юм. Улмаар бизнесийн идэвхижил саарч, эдийн засагт гадаад, дотоод орчны нөлөөгөөр аливаа эрсдэл үүсэхэд өөрийн хөрөнгөөрөө эрсдэлээ бүрэн хариуцах боломжтой болохыг харуулж байна.

Тайлант улиралд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 67 компаниар буюу 15.2 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 113-аар буюу 12.5 хувиар өссөн бол салбарт ажиллагсдын тоо 78 хүнээр нэмэгдэж 2028-д хүрсэн байна. Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харуулбал:

(Хүснэгт 6)

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015-III	2016-III	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
	Нийт ББСБ-ын тоо	442	509	67	15.2
	<i>Үүнээс: хөдөө орон нутагт</i>	51	59	8	15.7
	Харилцагчдын тоо	554,901	432,704	(122,197)	(22.0)
	Хувьцаа эзэмшигчдийн тоо	901	1,014	113	12.5
	Ажиллагсдын тоо	1,950	2,028	78	4.0
	Салбар нэгжийн тоо	110	123	13	11.8
	<i>Үүнээс: Улаанбаатар хотод</i>	76	89	13	17.1
	<i>Үүнээс: Хөдөө орон нутагт</i>	34	34	-	-
	Төлөөлөгчийн газар	4	4	-	-
	Зээлдэгчдийн тоо	47,123	64,278	17,155	36.4
	<i>Үүнээс: Хэвийн</i>	40,603	55,611	15,008	37.0
	<i>Хугацаа хэтэрсэн</i>	2,028	2,112	84	4.1
	<i>Чанаргүй</i>	4,492	6,555	2,063	45.9
	Нийт хөрөнгө	581,869,478.1	724,153,626.2	142,284,148	24.5
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	3.0	2.9	(0.1)	-2.0
	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	383,365,773.1	447,715,826.0	64,350,053	16.8
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	3.3	3.7	0.4	11.1
	Нийт өөрийн хөрөнгө	393,071,528.8	531,078,362.6	138,006,834	35.1
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	15.8	18.0	2.2	14.1
	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	298,281,559.4	401,613,200.3	103,331,641	34.6
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	53.5	68.1	14.6	27.3

Хороо байгуулагдсан үеэс буюу 2006-2016 оныг хүртэлх хугацааны тайлант үеийн харилцагчдын тоо, ББСБ-уудын тоо харгалзан дараах байдалтай байна. (дүрслэл 2)

ББСБ-уудын харилцагчдын тоо тайлант улиралд 122.2 мянгаар буурсан нь валют арилжааны ББСБ-дын харилцагчдын тоог бүрэн тайлагнаагүйтэй холбоотой.

Тоо баримтаас үзэхэд банк бус санхүүгийн салбар өргөжин тэлэхийн хэрээр харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо харьцангуйгаар нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

ББСБ-уудын зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 17,155-аар буюу 36.4 хувиар өссөн бөгөөд нийт зээлдэгчдийн 86.5 хувийг хэвийн, 3.3, 10.2 хувийг харгалзан хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлдэгчид эзэлж байна.


Улсын хэмжээнд 509 ББСБ тусгай зөвшөөрөлтэй байгаагийн 11.6 хувь буюу 59 нь хөдөө орон нутагт, 88.4 хувь буюу 450 нь хүн амын төвлөрлөө дагаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж

байна. ББСБ-ууд банк, санхүүгийн үйлчилгээний төвлөрөл, хүн амын нягтаршлыг дагаад Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хамгийн их төвлөрсөн байх ба харин Багахангай дүүрэгт одоогоор ББСБ байгуулагдаагүй байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувьд энэхүү үзүүлэлт Дорнод, Төв аймгуудад хамгийн их байгаа бол Говь-Алтай, Увс, Дорноговь аймгуудад ББСБ байгуулагдаагүй байна. Орон нутаг дахь ББСБ-уудын тоо нэмэгдсэнээр иргэдийг бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн үйлчилгээгээр дамжуулан шаардлагатай эх үүсвэрээр дэмжих зэрэг стратегийн чухал ач холбогдолтой бөгөөд улмаар иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэл нэмэгдэж, санхүүгийн боловсрол дээшилнэ гэж үзэж байна.

(Дүрслэл 2)

(Дүрслэл 4)



(Дүрслэл 3)



**ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**3.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт:**

Тайлант хугацааны ББСБ-уудын актив хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Хүснэгт 7

(мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	2015 III улирал		2016 III улирал		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	562,588,577.1	96.7	695,227,014.9	96.0	132,638,437.8	23.6
1	Мөнгөн хөрөнгө	147,632,642.7	25.4	210,184,086.2	29.0	62,551,443.6	42.4
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	11,385,945.1	2.0	1,300,516.7	0.2	(10,085,428.5)	(88.6)
3	Нийт зээл	383,365,773.9	65.9	447,715,826.0	61.8	64,350,052.0	16.8
	(Зээлийн эрсдлийн сан)	(23,371,596.1)	4.0	(37,903,797.3)	5.2	14,532,201.3	62.2
4	Нийт факторингийн тооцооны авлага	90,000.0	-	37,795.0	-	(52,205.0)	(58.0)
5	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	(30,000.0)	-	(30,000.0)	-	-	-
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон	2,209,693.1	0.4	3,240,263.4	0.4	1,030,570.2	46.6




	өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/						
7	Бусад хөрөнгө	41,306,118.3	7.1	70,682,325.1	9.8	29,376,206.7	71.1
Б	Эргэлтийн бус хөрөнгө /цэврээр/	19,280,901.9	3.3	28,926,611.2	4.0	9,645,709.3	50.0
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	24,743,715.2	4.3	36,185,870.4	5.0	11,442,155.2	46.2
	(Хуримтлагдсан элэгдэл)	(5,462,813.3)	0.9	(7,259,259.1)	1.0	1,796,445.8	32.9
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>581,869,479.0</b>	<b>100</b>	<b>724,153,626.2</b>	<b>100</b>	<b>142,284,147.2</b>	<b>24.5</b>

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 509 ББСБ-уудын нийт хөрөнгө 724.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 142.3 тэрбум төгрөгөөр буюу 24.5 хувиар, оны эхнээс 101.0 тэрбум төгрөгөөр буюу 16.2 хувиар тус тус өслөө. Активын өсөлтийг 2013, 2014 оны мөн үетэй харьцуулахад харгалзан 12.0, 17.9 нэгж хувиар буурсан буюу өсөлтийн хурдац харьцангуй саарч байна.


Нийт активын 96 хувийг эргэлтийн хөрөнгө, 4 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаагийн 56.6 хувь нь цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, 29 хувь нь мөнгөн хөрөнгө, 9.8 хувь нь бусад хөрөнгө, үлдэх хувь нь богино хугацаат хөрөнгө оруулалт, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө байна.

(Дүрслэл 5-6)

Банк бус санхүүгийн салбарын активын бүтэц



Нийт хөрөнгийн өсөлт /тэрбум төгрөгөөр/



Сүүлийн 3 жилийн тайлант үеийн дунджаар нийт хөрөнгийн 68.4 хувь нь эргэлтэд орсон байх ба 28 хувь нь мөнгөн хөрөнгө хэлбэрээр, 3.5 хувь нь үндсэн хөрөнгө хэлбэрээр байршиж байна.

**3.2 Зээлийн багцын чанар:**

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 7

(мянган төгрөгөөр)

№	Ангилал	2015 III улирал		2016 III улирал		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
	Хэвийн	326,267,436.3	85.1	369,664,299.4	82.6	43,396,863.1	13.3
2	Хугацаа хэтэрсэн	22,151,882.0	5.8	21,872,012.1	4.9	(279,869.9)	(1.3)
3	Чанаргүй зээл: Үүнээс	34,946,455.6	9.1	56,179,514.4	12.5	21,233,058.8	60.8
	Хэвийн бус	10,434,289.0	2.7	16,664,744.2	3.7	6,230,455.2	59.7
	Эргэлзээтэй	10,622,391.0	2.8	15,660,921.7	3.5	5,038,530.7	47.4
	Муу	13,889,775.6	3.6	23,853,848.5	5.3	9,964,072.9	71.7
4	(Зээлийн эрсдэлийн сан)	23,371,596.1	6.1	37,903,797.3	8.5	14,532,201.2	62.2
<b>Нийт зээл</b>		<b>383,365,773.9</b>	<b>100</b>	<b>447,715,826.0</b>	<b>100</b>	<b>64,350,052.1</b>	<b>16.8</b>
1	Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл	340,401,056.5	88.8	408,474,617.0	91.2	68,073,560.5	20.0
2	Гадаад валютаар олгосон зээл	42,964,717.4	11.2	39,241,209.0	8.8	(3,723,508.4)	(8.7)

Тайлант хугацаанд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар буюу 64.4 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 14.4 хувиар буюу 56.5 тэрбум төгрөгөөр өсч 447.7 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт зээлд эзлэх гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар буурч, төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 68.1

тэрбум төгрөгөөр буюу 20 хувиар өссөн нь төгрөгийн валюттай харьцах ханш суларснаас төгрөгийн зээлийн эрэлт ихэссэнийг харуулж байна.

Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 60.8 хувиар өсч, нийт зээлийн 12.5 хувийг эзэлж байна. Зээлийн эрсдэлийн санд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ нийт чанаргүй зээлийн 48.6 хувьтай тэнцэж байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангиллын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 21.2 тэрбум төгрөгөөр буюу 60.8 хувиар өссөн явдал нь муу зээлийн хэмжээ 71.7 хувиар өссөнтэй шууд хамааралтай. ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

(Дүрслэл 7)




Түүнчлэн зээлийн өрийн үлдэгдэл нь 100% чанаргүй ангилалд ангилагдсан нэр бүхий 4 ББСБ-ын 378.6 сая төгрөгийн зээл, 85 хувиас дээш хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан нэр бүхий 4 ББСБ-ын 6.3 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, компанийн гүйцэтгэх удирдлага үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**3.3 Зээлийн зориулалт**

(Дүрслэл 8)


Тайлант улирлын байдлаар нийт 309.5 тэрбум төгрөгийн зээл олгож, үүнээс 251.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн буюу нийт зээлийн өрийн үлдэгдэл 447.7 тэрбум төгрөг байна. /Тайлант оны эхний үлдэгдэл 389.7 тэрбум төгрөг байсан./



Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл хэрэглээний зээлд 39.2 хувь буюу 121.2 тэрбум төгрөг, худалдааны салбарт 23.1 хувь буюу 71.4 тэрбум төгрөг, барилгын салбарт 14 хувь буюу 43.4 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт 3.9 хувь буюу 12 тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл, хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагааны салбарт тус тус 3.6 хувь буюу нийт 22.5 тэрбум төгрөг, бусад салбаруудад 12.6 хувь буюу нийт 39 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Түүнчлэн нийт зээлийн үлдэгдлийн 37 хувийг хэрэглээний зээл, 23.9 хувийг худалдааны салбар, 15.4 хувийг барилгын салбар, 4.5 хувийг уул уурхайн салбар, 4.3 хувийг эрүүл мэндийн салбар үлдэх 14.5 хувийг бусад салбар эзэлж байна.






### 3.4 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 454 ББСБ-ын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 4.2 хувьтай байна.

Зээлийн хүүг бууруулахад гаднаас хямд өртөгтэй эх үүсвэр татах, үйл ажиллагааны зардлаа бууруулах, зээлдэгчдийн эрсдэлийг үнэлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

(Дүрслэл 10)



### 3.5 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Тайлант улиралд 15 ББСБ богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд 1.3 тэрбум төгрөгийг байршуулсны 89.7 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг 1 компанийн хувьцаагаарх хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байна. Бусад нэр бүхий 14 ББСБ-ын хувьд 1 сая төгрөгөөс 33.9 сая хүртэлх хэмжээний мөнгөн хөрөнгийг арилжааны болон хөрөнгө оруулалтын үнэт цаасанд байршуулсан байна.

2016 оны гуравдугаар улиралд нэр бүхий 2 ББСБ-ын факторингийн тооцооны авлага данс 37.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас нэр бүхий 1 компанийн 30 сая төгрөгийн авлага муу ангилалд ангилагдан эрсдэлийн сан байгуулсан байна. Тус компани авлагын эрсдэлийн санг 2015 оны хоёрдугаар улиралд байгуулсан хэдий ч "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу шат дараалсан арга хэмжээг авахгүйгээр тайлан тэнцэлд тусгасаар байна. Харин нэр бүхий 1 компанийн хувьд 70 сая төгрөгийн факторингийн тооцооны авлагаас 62.2 сая төгрөгийн авлага эргэн төлөгдөж, 7.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 509 ББСБ-ын 36.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөд 7.3 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байх ба хөрөнгийн бүрэлдэхүүнийг харуулбал:

#### Хүснэгт 8

(мянган төгрөгөөр)

ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)		28,926,611.2
Үндсэн ба биет бус хөрөнгө		36,185,870.4
Барилга байгууламж	1901	11,760,673.3
Техник хэрэгсэл	1902	12,530,963.0
Тавилга эд хогшил	1903	5,023,139.0
Дуусаагүй барилга /үндсэн хөрөнгийн санхүүжилт/	1904	2,427,597.3

Биет бус хөрөнгө	1905	4,443,497.7
<i>Хуримтлагдсан элэгдэл</i>		<i>7,259,259.1</i>
<i>Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл</i>	1911	<i>685,309.8</i>
<i>Техник хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл</i>	1912	<i>4,576,452.9</i>
<i>Тавилга эд хогшилийн хуримтлагдсан элэгдэл</i>	1913	<i>1,997,496.4</i>

**ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ**

2016 оны гуравдугаар улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орсон байна.


**Хүснэгт 9**

(мянган төгрөгөөр)


№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2015 III улирал		2016.III улирал		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
A	Нийт өр төлбөр	188,797,950.3	32.4	193,075,263.5	26.7	4,277,313.2	2.3
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	31,921,182.1	5.5	28,389,604.7	3.9	(3,531,577.5)	-11.1
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	124,825,941.2	21.5	116,158,999.7	16.0	(8,666,941.5)	(6.9)
3	Бусад эх үүсвэр	2,491,220.1	0.4	3,526,210.6	0.5	1,034,990.5	41.5
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	1,513,742.5	0.3	4,298,856.5	0.6	2,785,114.0	184.0
5	Төслийн зээлийн санхүүжилт	14,560,689.2	2.5	19,326,278.8	2.7	4,765,589.6	32.7
6	Бусад өр төлбөр	13,485,175.2	2.3	21,375,313.2	3.0	7,890,138.0	58.5
B	Өөрийн хөрөнгө	393,071,528.7	67.6	531,078,362.6	73.3	138,006,833.9	35.1
9	Хувьцаат капитал	298,281,559.4	51.3	401,613,200.3	55.5	103,331,640.9	34.6
10	Бусад өмч	9,364,477.9	1.6	8,360,755.9	1.2	(1,003,722.0)	(10.7)
11	Сангууд	337,276.7	0.1	481,732.6	0.1	144,455.9	42.8
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	83,686,802.1	14.4	119,623,918.0	16.5	35,937,115.9	42.9
13	Хоёрдогч өглөг	1,401,412.6	0.2	998,755.8	0.1	(402,656.8)	(28.7)
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>581,869,479.0</b>	<b>100</b>	<b>724,153,626.2</b>	<b>100</b>	<b>142,284,147.1</b>	<b>24.5</b>

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 193.1 тэрбум төгрөг буюу 26.7 хувийг бусдаас татсан эх үүсвэр, 531.1 тэрбум төгрөг буюу 73.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаагийн 55 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 16.5 хувийг хуримтлагдсан ашиг, 16 хувийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 3.9 хувийг итгэлцлийн үйлчилгээний өр, үлдсэн хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна. Сүүлийн 1 жилийн хугацаанд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийн тоо өмнөх онуудаас буурсан боловч Хорооноос дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсээр байна.

(Дүрслэл 11)



(Дүрслэл 12)





Нийт эх үүсвэрийн хэмжээ 2016 оны гуравдугаар улирлын эцэст 193.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар, оны эхнээс 9.9 хувиар тус тус өслөө.

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 103.3 тэрбум төгрөгөөр буюу 34.6 хувиар өссөн үзүүлэлтэд 2016 онд тусгай зөвшөөрөл олгосон 63 компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болох 50 тэрбум төгрөг 48.4 хувийг эзэлж байна.

ББСБ-ууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг сайжруулж, мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой билээ. Түүнчлэн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо хийгээд ББСБ-уудын хуримтлагдсан ашиг жилээс жилд хурдацтай нэмэгдсээр байна.

(Дүрслэл 13)

(Дүрслэл 14)



Сүүлийн 4 жилийн тайлант үеийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашгийн хамаарлыг харахад 2013, 2014 онуудад харгалзан өндөр өсөлттэй байсан бол 2015 оноос эхлэн тус үзүүлэлт буурах хандлага ажиглагдаж байна.

2016 оны тайлант үеийн байдлаар тусгай зөвшөөрөл авсан 28 ББСБ-ын 21 ББСБ 28.4 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт өрийн 14.7 хувьтай тэнцэж байна. Нэр бүхий 3 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний өрийн үлдэгдэл нь харгалзан нийт итгэлцлээр татсан хөрөнгийн 10.9, 11.6, 16.3 хүртэлх хувийг эзэлж байх ба харин нэр бүхий 6 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхлээгүй байна.

Эдгээр ББСБ-уудын нийт хөрөнгө нь салбарын нийт хөрөнгийн 25.8 хувь, өөрийн хөрөнгө нь салбарын мөн үзүүлэлтийн 21.6 хувийг тус тус эзэлж байна.

2016 оны гуравдугаар улирлын байдлаар нэр бүхий 3 ББСБ-ын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 936.6 сая төгрөг, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 2.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Түүнчлэн нэр бүхий 6 ББСБ нийт 998.8 сая төгрөгийг хоёрдогч өглөгөөр, 7 ББСБ нийт 4.3 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны статистик мэдээллээс үзэхэд 39 ББСБ бичил санхүүгийн хөгжлийн сангийн бөөний зээлд хамрагдаж, 6.7 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна. Бичил санхүүгийн хөгжлийн сангаас бөөний зээлд хамрагдах хүсэлтэй ББСБ-ууд дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ✓ Активын өгөөж (АӨ) үзүүлэлт нь 1.5 хувиас дээш;
- ✓ Монголбанк, СЗХ-ноос тавьсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 улирлын турш ханган ажилласан;
- ✓ Чанаргүй зээлийн хэмжээ нь Монгол банкинд мэдээлсэн зээлийн өрийн үлдэгдлийн 5 хувиас ихгүй;
- ✓ Зээлийн алдагдлаас хамгаалах санг Монгол банкны шаардлагын дагуу байгуулсан байх.

#### ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант улиралд ББСБ-уудын ашигт ажиллагаа өмнөх оны мөн үеэс дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

##### Хүснэгт 12

(мянган төгрөгөөр)

Б	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	28,536,332.0	24.7	40,239,208.4	28.1	11,702,876.3	41.0
	Арилжааны орлого	2,343,716.6	2.0	2,608,615.8	1.8	264,899.2	11.3
	Гадаад валютын арилжааны орлого	2,343,716.6	2.0	2,608,615.8	1.8	264,899.2	11.3
	Үнэт цаасны арилжааны орлого	-	-	-	-	-	-
	Ханш болон үнэлгээний тэгшигтгэлийн орлого	21,222,903.2	18.4	28,921,271.1	20.2	7,698,368.0	36.3
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	21,222,903.2	18.4	28,921,271.1	20.2	7,698,368.0	36.3
	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	-	-	-	-	-
	Санхүүгийн үйлчилгээний орлого	4,969,712.3	4.3	8,709,321.5	6.1	3,739,609.2	75.2
	Санхүүгийн түрээсийн орлого	-	-	-	-	-	-
	Итгэлцлийн үйлчилгээний орлого	3,120.1	-	184.9	-	(2,935.2)	(94.1)
	Мөнгөн гуйвуулгын орлого	485,767.8	0.4	445,082.4	0.3	(40,685.4)	(8.4)
	Картын үйлчилгээний орлого	750.0	-	-	-	(750.0)	(100)
	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	539,538.4	0.5	3,811,390.3	2.7	3,271,851.8	606.4
	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	3,275,903.8	2.8	3,086,783.2	2.2	(189,120.6)	(5.8)
	Бусад	664,632.2	0.6	1,365,880.7	1.0	701,248.5	105.5
В	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,348,841.4	1.2	2,637,091.1	1.8	1,288,249.7	95.5
	Алданги	543,755.0	0.5	807,405.7	0.6	263,650.7	48.5
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	30,144.6	0.0	80,022.5	0.1	49,877.9	165.5
	Ногдол ашгийн орлого	100.0	0.0	83.1	-	(16.9)	(16.9)

	Хандив	80,262.2	0.1	5,000.0	-	(75,262.2)	(93.8)
	Тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөгдөлт	66,465.8	0.1	105,843.3	0.1	39,377.5	59.2
	Бусад	628,113.9	0.5	1,638,736.6	1.1	1,010,622.6	160.9
Г	Ердийн бус орлого	-	-	-	-	-	-
<b>НИЙТ</b>		<b>115,496,157.2</b>	<b>100</b>	<b>143,286,533.7</b>	<b>100</b>	<b>27,790,376.5</b>	<b>24.1</b>

ББСБ-уудын үндсэн үйл ажиллагааны буюу хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өсөж, нийт орлогын 70.1 хувийг, хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 41 хувиар өсөж, нийт орлогын 28.1 хувийг бүрдүүлж байна. Харин нийт орлогын дүнд эзлэх үндсэн бус үйл ажиллагааны орлого өмнөх оны мөн үеэс 95.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2016 оны гуравдугаар улирлын байдлаар нийт хүүгийн орлогын 95 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, хүүгийн бус орлогын 71.9 хувийг гадаад валютын арилжааны орлого, 75.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 21.6 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого, үндсэн бус үйл ажиллагааны орлогын 30.6 хувийг торгууль, алдангийн орлого тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс харгалзан 0.7-9.7 хувиар өссөн үзүүлэлт юм.

Нийт зардлын бүтцэд тайлант улиралд дараах өөрчлөлт орсон байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

### Хүснэгт 13

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2015 III улирал		2016 III улирал		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1	Хүүгийн зардал	11,060,379.1	13.4	11,705,779.8	11.8	645,400.7	5.8
2	Хүүгийн бус зардал	55,661,603.7	67.6	64,598,832.3	65.2	8,937,228.6	16.1
3	Болзошгүй эрсдэлийн зардал	10,604,801.3	12.9	16,339,661.7	16.5	5,734,860.3	54.1
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	648,165.3	0.8	1,056,087.8	1.1	407,922.5	62.9
5	Ердийн бус зардал	11.6	-	-	-	(11.6)	(100)
6	Орлогын татварын зардал	4,345,472.4	5.3	5,318,860.8	5.4	973,388.4	22.4
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>82,320,433.3</b>	<b>100</b>	<b>99,019,222.4</b>	<b>100</b>	<b>16,698,789.1</b>	<b>20.3</b>

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 20.3 хувиар, үүний дотор хүүгийн зардал 5.8 хувиар, хүүгийн бус зардал 16.1 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 54.1 хувиар, орлогын татварын зардал 22.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 62.9 хувиар тус тус өссөн байна.

### Хүснэгт 13-а

(мянган төгрөгөөр)


№	Үзүүлэлт	2015 III улирал		2016 III улирал		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1	Нийт орлого	115,496,157.2	100.0%	143,286,533.7	100.0%	27,790,376.5	24.1%
2	Нийт зарлага	82,320,433.3	100.0%	99,019,222.4	100.0%	16,698,789.1	20.3%
<b>ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ</b>		<b>33,175,723.9</b>	<b>-</b>	<b>44,267,311.3</b>	<b>-</b>	<b>11,091,587.4</b>	<b>33.4%</b>

Тайлант хугацаанд нийт 44.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.1 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулбал:

### (Дүрслэл 15)

**Ашигт ажиллагааны үзүүлэлт  
/тэрбум төгрөгөөр/**





Салбарын хэмжээнд нийт 509 ББСБ-ын 77.4 хувь буюу 394 ББСБ 48.9 тэрбум төгрөгийн ашигтай, 4.9 хувь буюу 25 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 17.7 хувь буюу 90 ББСБ 4.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## ЗУРГАА. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

### **6.1 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:**

Тайлант улиралд орон нутагт төвтэй 59 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2015 оны мөн үеэс 8 компаниар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-ын 55 ББСБ нь зээл санхүүжилтийн, 2 ББСБ тус тус валют арилжааны, хөрөнгө удирдлагын ББСБ-ын ангилалд хамрагдан үйл ажиллагаа эрхэлж байна.

Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын актив хөрөнгө нь салбарын нийт активын 2.7 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь 3 хувь, өөрийн хөрөнгө нь 3.3 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3.4 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

#### *Хүснэгт 14*

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны III улирал	2016 оны III улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	51	59	8
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>11.5%</i>	<i>11.6%</i>	<i>0.1%</i>
А	Нийт актив	15,773,582.9	19,593,761.3	3,820,178.4
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2.7%</i>	<i>2.7%</i>	<i>0.0%</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	12,060,810.7	13,610,721.6	1,549,910.9
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>2.1%</i>	<i>3.0%</i>	<i>0.9%</i>
	Чанаргүй зээл	439,549.8	483,768.7	44,218.9
	<i>ББСБ-ын нийт чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>1.3%</i>	<i>0.9%</i>	<i>(0.4%)</i>
В	Нийт өөрийн хөрөнгө	12,625,312.2	17,679,152.2	5,053,840.0
	<i>ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь</i>	<i>3.2%</i>	<i>3.3%</i>	<i>0.1%</i>
Г	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	8,198,179.5	13,854,489.8	5,656,310.3
	<i>ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь</i>	<i>2.7%</i>	<i>3.4%</i>	<i>0.7%</i>

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өсөлттэй байгаа ба чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өссөн хэдий ч оны эхнээс 15.4 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа.

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх үндсэн зорилтын хүрээнд орон нутаг дахь төлөөлөгчдөд зориулсан сургалт, семинарыг тогтмол зохион байгуулж, иргэдэд чиглэсэн мэдээлэл, заавар, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаж байгаагийн дүнд сүүлийн жилүүдэд орон нутагт үйл ажиллагаа эрхлэх ББСБ-ын тоо нэмэгдсээр байна. Тухайлбал 2013-2015 оныг хүртэлх хугацаанд 21 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх ба он гарсаар 10 ББСБ-д үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна. Тоо баримтаас үзэхэд УБ хотод төвтэй 15 ББСБ 34 салбар, 2 төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

### **6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

Тайлант улиралд гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 30 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 5.9 хувь, тэдгээрийн актив нь салбарын 16.1 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь салбарын 18.4 хувь, өөрийн хөрөнгө нь салбарын 11.8 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын 12.7 хувийг тус тус эзэлж байна.

#### *Хүснэгт 15*

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015-III	2016-III	өсөлт +/-, бууралт -/-
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	25	30	5
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>5.6%</i>	<i>5.9%</i>	<i>0.3%</i>
А	Нийт актив	88,937,047.9	116,387,523.2	27,450,475.3

<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>		<i>15.3%</i>	<i>16.1%</i>	<i>0.8%</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	69,592,669.2	82,529,208.1	12,936,538.9
	Үүнээс: Чанаргүй зээл	7,712,568.0	11,886,446.2	4,173,878.2
<i>Нийт ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		<i>18.1</i>	<i>18.4</i>	<i>(0.3)</i>
В	Нийт өөрийн хөрөнгө	52,254,599.7	58,440,523.2	6,185,923.5
	<i>ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь</i>	<i>13.3</i>	<i>11.0</i>	<i>(2.3)</i>
Г	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	38,885,199.9	50,992,766.6	12,107,566.7
	<i>ББСБ-ын нийт хувь хөрөнгөд эзлэх хувь</i>	<i>13.0%</i>	<i>12.7%</i>	<i>(0.3)</i>

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 11, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, Хонг Конгийн хөрөнгө оруулалттай 3, АНУ-ын хөрөнгө оруулалттай 2, Хятад, Орос, Сичель, Франц, Англи, Люксембург, Малайз, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

### **6.3 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:**

Хорооноос тайлант хугацаанд 2 компанид гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 2 ББСБ-д нэмж олгох, 2 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацааны эцэст Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 509 ББСБ-ын 28.1 хувь буюу 143 ББСБ гадаад валютын арилжаа эрхэлж байгаагийн 35.7 хувь буюу 51 компани нь дагнан эрхэлж байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

#### *Хүснэгт 17*

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны	2016 оны	өсөлт +/-,
		III улирал	III улирал	бууралт -/-
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	52	51	(1)
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>11.7</i>	<i>10.0</i>	<i>(1.7)</i>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	9,574,808.1	10,327,363.3	752,555.2
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>1.6</i>	<i>1.4</i>	<i>(0.2)</i>
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	9,514,116.9	10,223,330.8	709,213.9
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>3.2</i>	<i>1.9</i>	<i>(1.3)</i>
В	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/	9,027,550.0	9,524,076.4	496,526.4
	<i>ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь</i>	<i>3</i>	<i>2.4</i>	<i>(0.6)</i>

Тайлант улиралд арилжаанд орсон гадаад валютуудын зах зээл дэх ханшийн хэлбэлзлийг үзүүлбэл:

#### *Хүснэгт 18*

Д/д	Валют	Худалдаж авсан ханш /дундаж ханш/			Худалдсан ханш /дундаж ханш/		
		31/07/2016	31/08/2016	30/09/2016	31/07/2016	31/08/2016	30/09/2016
1	АНУ доллар	2,025.10	2,189.34	2,230.95	2,042.29	2,203.48	2,242.04
2	Евро	2,242.22	2,461.42	2,512.56	2,278.19	2,474.22	2,499.74
3	Японы иен	19.34	20.97	21.61	19.65	21.61	22.10
4	Швейцар франк	2,023.35	2,285.00	2,276.71	2,089.10	2,296.67	2,288.83
5	Шведийн крон	218.80	-	-	240.00	-	-
6	Английн фунт	2,679.91	2,892.55	2,827.36	2,775.07	2,922.31	2,827.39
10	Энэтхэгийн рупи	28.00	-	-	33.00	-	-
11	Хонгконг доллар	256.95	274.75	288.13	262.37	276.90	291.00
12	ОХУ-ын рубль	31.54	34.36	34.94	32.64	35.18	35.45
14	БНХАУ-ын юань	306.11	328.57	335.95	309.44	332.56	337.99
15	БНСУ-ын вон	1.72	1.47	1.97	1.76	1.74	2.00
16	БНАСАУ-ын вон	-	-	-	-	-	2.04
17	Канадын доллар	1,533.68	1,650.40	1,673.33	1,579.75	1,702.50	1,735.00

18	Австралийн доллар	1,513.82	1,638.97	1,656.96	1,561.67	1,647.97	1,686.63
21	Тайланд бат	57.32	-	-	65.00	-	-
23	Малайзын ринггит	455.79	-	-	550.00	-	-
24	Сингапур доллар	1,464.21	1,610.35	1,602.50	1,550.00	1,636.75	1,651.00

Валют арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 123 ББСБ-ууд тайлант улирлын өссөн дүнгээр нийт 708.4 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 746.4 тэрбум төгрөгийн валют худалсан байна. Ирсэн тайлан, мэдээнээс үзэхэд нийт худалдаж авсан валютын 46.6 хувь буюу 330.3 тэрбум төгрөгт ам.доллар, 37.7 хувь буюу 266.9 тэрбум төгрөгт юань, 7.2 хувь буюу 50.8 тэрбум төгрөгт евро тус тус худалдаж авсан бол нийт зарсан валютын 46.5 хувь буюу 346.8 тэрбум төгрөгт ам.доллар, 38.9 хувь буюу 290.2 тэрбум төгрөгт юань, 6.4 хувь буюу 47.9 тэрбум төгрөгт евро тус тус зарсан байна.

## ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-ын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож үзэхэд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

### *1/ Валют арилжааны ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:*

#### *Хүснэгт 19*

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	49	90.7
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	3.7
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	5.6
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
<b>НИЙТ</b>		<b>54</b>	<b>100.0</b>

Валют арилжааны ББСБ-уудын тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

- нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 94.4 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлага 92.6 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

- төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

- үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 98.1 хувиар;

- өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

### *Зээл санхүүжилтын ББСБ зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:*

#### *Хүснэгт 20*

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	300	73.7
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	68	16.7
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	27	6.6
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	5	1.2
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	7	1.7
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
<b>НИЙТ</b>		<b>396</b>	<b>100.0</b>

Зээл санхүүжилтын ББСБ-ын тооцвол зохих 14 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

- нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 96.3 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 96.0 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 99.0 хувиар;

- төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 96.8 хувиар;

- активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт 99.3 хувиар;

- нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлага 94.3 хувиар;

- нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлага 96.8 хувиар;

- нэгдмэл сонирхолтой этгээдүүдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлтийн нийт дүн нь 25 хувиас ихгүй байх шаардлага 97.5 хувиар;

- үнэт цаасны төвлөрлийн үзүүлэлт 20 хувиас ихгүй байх шаардлага 99.8 хувиар;

- нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 10 хувиас ихгүй байхгүй шаардлага бүрэн;

- ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага 96.1 хувиар;

- нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 93.9 хувиар;

- цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлага 93.6 хувиар;

- өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

### ***Хөрөнгө удирдлагын ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт:***

#### ***Хүснэгт 21***

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	28	58.3
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	15	31.3
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	8.3
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	2.1
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
	<b>НИЙТ</b>	<b>48</b>	<b>100.0</b>

Хөрөнгө удирдлагын ББСБ-ын тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага тус тус 97.9 хувиар;

- активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт бүрэн;

- нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлага 95.8 хувиар;

- нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 10 хувиас ихгүй байх, нийлбэр нь 25 хувиас ихгүй байх шаардлага тус тус 97.9 хувиар;

- үнэт цаасны төвлөрлийн үзүүлэлт 50 хувиас ихгүй байх шаардлага 97.9 хувиар;
- нэг компаниас худалдан авах хувьцаа, үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа тус тус 20 хувиас ихгүй байх шаардлагууд бүрэн;
- ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага 83.3 хувиар;
- нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 95.8 хувиар;
- итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
- цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлага 97.9 хувиар;
- өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

## НАЙМ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. 2016 онд нийт 396 ББСБ-аас 571,576.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 382 ББСБ 566,933.0 мянган төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн буюу биелэлт 99.2 хувьтай байна.

2. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 454 ББСБ-ын 72.7 хувь буюу 330 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.

3. Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг тайлант улиралд 446 ББСБ-ын 65 хувь буюу 290 ББСБ хэрэгжүүлсэн байна.

4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд 2 удаагийн тохиолдлоор нэр бүхий 2 ББСБ 234.4 сая төгрөгийн сэжигтэй гүйлгээ, 80 ББСБ 2765 удаагийн тохиолдлоор 59,889.3 сая төгрөгийн 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

## ЕС. ДҮГНЭЛТ

Тусгай зөвшөөрөлтэй 509 ББСБ-дын 95.7 хувь нь буюу 487 ББСБ 2016 оны гуравдугаар улирлын байдлаар тайлан, мэдээгээ зохих журмын дагуу ирүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар, энэ оны хоёрдугаар улирлаас 4.3 хувиар нэмэгдсэн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 1.3 дахь ангиллын хүрээнд тайлант хугацаанд валют арилжааны чиглэлийн 54, зээл, санхүүжилтийн чиглэлийн 407, хөрөнгийн удирдлагын 48, нийт 509 ББСБ тусгай зөвшөөрөлтэй байгаагийн 11.6 хувь буюу 59 нь хөдөө орон нутагт, 88.4 хувь буюу 450 нь хүн амын төвлөрлөө дагаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүн нэгтгэлээрх нийт активын төвлөрлийг харахад 10.0 тэрбум төгрөгөөс дээш активтай 13 ББСБ-ын 241.9 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 33.4 хувийг, 5.0 тэрбумаас 9.3 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 12 ББСБ-ын 81.4 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 11.4 хувийг, 1.0 тэрбумаас 4.8 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 114 ББСБ-ын 219.3 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 30.3 хувийг, 400.0 сая төгрөгөөс 999.0 сая хүртэлх төгрөгийн активтай 256 ББСБ-ын 163.9 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 22.6 хувийг, 20.0 сая төгрөгөөс 399.0 сая төгрөгийн активтай ББСБ-ын 17.6 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 2.4 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл 139 ББСБ буюу нийт ББСБ-ын 27.3 хувь нь нийт активын 75.1 хувийг эзэлж байна.



Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт актив 724.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 2.9 хувь, зээлийн өрийн үлдэгдэл 447.7 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.7 хувь, өөрийн хөрөнгө 531.1 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 18.0 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 401.6 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 68.1 хувьтай тус тус тэнцэж байна.

Нийт активын 61.8 хувийг зээлийн өрийн үлдэгдэл, 29.0 хувийг мөнгөн хөрөнгө /эдгээр нь нийт активын 90.8 хувь/ эзэлж байгаа нь нэг талаас системийн хэмжээнд нийт эх үүсвэрийн байршуулалт төдийлэн хангалтгүй байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө зөв оновчтой удирдан зохион байгуулж, нийт ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой атал ББСБ-ууд зээлийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг төдийлэн эрхлэхгүй байна.

Түүнчлэн Монгол улсын эдийн засгийн бууралт, иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зээлийн чанартай холбоотойгоор тайлант үеийн байдлаар нийт 210.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаагаас /5.3 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг төлбөр түргэн гүйцэх чадварт нөөцлөгдөж, 11.8 тэрбум төгрөг буюу 5.6 хувийг валют арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ-д байршсан/ 193.1 тэрбум төгрөг буюу 91.8 хувь эргэлтэд ороогүй байна. Нийт олгосон зээлийн үлдэгдэл нь өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар, 2014 оны мөн үеэс 30.4 хувиар тус тус буурсан байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 21.2 тэрбум төгрөгөөр буюу 60.8 хувиар өссөн явдал нь муу зээлийн хэмжээ 71.7 хувиар өссөнтэй шууд хамааралтай байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр ББСБ-ууд нь 1.0 төгрөгийн өөрийн хөрөнгөөс 0.06 мөнгөний ашиг олж байгаа нь /2016 оны 3 дугаар улирлын тайлангийн нэгтгэлд эхлэлтийн тайлан тэнцэл бүхий 10, өмнөх тайлант хугацаануудын тайлан тэнцэл бүхий 12 ББСБ хамрагдсан/, 90 ББСБ нийт 4.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан зэрэг нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа ба салбарын хэмжээгээр ББСБ-уудын активын өгөөж 14.8 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 10.4 хувьтай байна.

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 73.3 хувийг буюу 531.1 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр, 18.7 хувийг буюу 135.4 тэрбум төгрөгийг дотоод гадаадын банк санхүүгийн байгууллага, төслийн зээлийн санхүүжилтээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр, 3.9 хувь буюу 28.3 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээний өглөгөөр бүрдүүлж байгаа нь ББСБ-ууд системийн хэмжээгээр өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой холбоотой.

Нийт ББСБ-ын 394 ББСБ буюу 77.4 хувь нь 48.8 тэрбум төгрөгийн ашигтай, 90 ББСБ буюу 17.7 хувь нь 4.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол харин 25 ББСБ буюу 4.9 хувь нь үйл ажиллагаа эрхлээгүй бөгөөд системийн хэмжээгээр тайлант хугацаанд нийт 44.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.1 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**